



БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ



2013 ОН
ЭРДЭНЭТ ХОТ

ГАРЧИГ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 ОН

ЭЭЛЖИТ III ХУРАЛДААН /2013.01.31/

№02. Үндсэн чиглэл батлах тухай.....	3
№03. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай.....	4
№04. Үндсэн чиглэл батлах тухай.....	5
№05. “Сумын 2013 оны төсөв батлах” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.....	6-9
№06. Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тогтоох тухай.....	10-11
№07. Зээлийн хэмжээ, хүү, хугацааг тогтоох тухай	12
№08. Орон тооны бус зөвлөл байгуулах тухай.....	13
№09. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн ажиллах журам батлах тухай.....	14-17
№10. Хяналтын ажлын хэсэг байгуулах тухай.....	18

ЭЭЛЖИТ IV ХУРАЛДААН /2013.03.29/

№02. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны төсвийг шинэчлэн батлах тухай.....	19
№03. Сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай.....	20-31
№04. Бэлчээрийн менежментийг төлөвлөгөөг батлах тухай.....	32-33

ЭЭЛЖИТ V ХУРАЛДААН /2013.10.11/

№02. ОНХС-ын зарцуулалтын тухай.....	34
№03. 2013 оны ОНХС-н төсөвт тодотгол хийх тухай.....	35
№04. Сум хөгжүүлэх сангийн тухай.....	36

ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААН /2013.11.22/

№02. Сумын нутаг дэвсгэрт 2014 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээг эрэмбэлэх тухай.....	37-46
№03. Төсөвт тодотгол хийх тухай	47

№04. Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай.....	48
---	----

ЭЭЛЖИТ VII ХУРАЛДААН /2013.12.18/

№02. 2013 оны үндсэн чиглэлийн биелэлтийн тухай.....	49
№03. Сумын эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай.....	50-69
№04. Сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай.....	70-76
№05. Баян-Өндөр сумын 2014 оны төсөв батлах тухай.....	77-79
№06. ИТХ-ын үйл ажиллагааны 2013 оны төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт өгөх тухай.....	80

ЭЭЛЖИТ БУС III ХУРАЛДААН /2014.09.25/

№02. Шинээр баг байгуулах тухай.....	81-83
№03. Хилийн цэсийн цэгүүдийг зөвшөөрөх тухай.....	84-86



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хийх ажлын үндсэн чиглэлийн төслийн тухай ИТХ-ын дарга Н.Жаргалсайханы илтгэл, үндсэн чиглэлийн төслийг хэлэлцээд ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хийх ажлын үндсэн чиглэлийг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2.Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, ажлын явц, үр дүнг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд мэдээлж байхыг ИТХ-ын дарга /Н.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

**Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр,
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1."д" заалтыг үндэслэн Баян-Өндөр сумын Засаг дарга И.Баасанжавын илтгэлийг хэлэлцээд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж хагас жилд Тэргүүлэгчдийн хуралд, бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд биелэлтийг тооцон тайлагнаж байхыг Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1."д" заалтыг үндэслэн Баян-Өндөр сумын Засаг дарга И.Баасанжавын илтгэлийг хэлэлцээд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баян-Өндөр сумын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2. Үндсэн чиглэлийн биелэлт, үр дүнг хагас жилд Тэргүүлэгчдийн хуралд, жил тутам Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд илтгэж байхыг Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 05

Эрдэнэт

**“Сумын 2013 оны төсөв батлах” тогтоолын
хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Сумын 2013 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолын долоодугаар зүйлийн 1 дүгээр хавсралт, наймдугаар зүйлийн 3 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж хавсалтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит II хуралдааны 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Сумын 2013 оны төсөв батлах” 02 дугаар тогтоолын долоодугаар зүйлийн 1 дүгээр хавсралт, наймдугаар зүйлийн 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын

6 дахь удаагийн сонгуулийн ээлжит III хуралдааны
05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН

Д/Д	Төсвийн эрх захирагч нар, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв /сая төгрөг/
		Чанар	Тоо	
Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				
1.	Засаг дарга			2.643.438.00
1.1.	Хөрөнгө оруулалт			1,427,138,00
1.1.1.	Гэр хорооллын багуудын гудамж, талбайн гэрэлтүүлэг хийх	Орчныг бүрэн гэрэлтүүлж аюулгүй орчин бүрдүүлэх, өнгө, үзэмж сайжирсан байна.	Гэр хорооллын 11 багт	200,000,00
1.1.2.	Үерийн усанд эвдэгдсэн газар ус зайлуулах, далан суваг сэргээн засварлах	Үер усны аюулаас урьдчилан сэргийлж айл өрх үерт автах эрсдэл буурна	5-6 багийн далан сэргээн засварлана	50,000,00
1.1.3.	Ирээдүйн-Одод сургуулийн спорт заалны барилгын дутуу ажлын гүйцэтгэл	Биеийн тамирын хичээлийн сургалтын орчин сайжирч сурагчдын суралцах нөхцлийг хангана	1 спорт заал	100,000,00
1.1.4.	Нийтийн аж ахуйн үйлчилгээний зориулалтаар гэр хорооллыг ундны усаарх хангах зөөврийн усны автомашин	Гэр хорооллын айл өрхийн цэвэр усны хангамж, сайжирна	2 автомашин	84,000,00
1.1.5.	Орон сууцны хорооллын байр хооронд 8-аас доошгүй газарт амралт, чөлөөт цагийн талбайтай ногоон байгууламж бүхий иж бүрэн тохижилтийг хийх	Иргэдийн амарч, чөлөөт цаг өнгөрүүлэх ая тухтай нөхцөл бүрдэнэ.	8 ш иж бүрэн байгууламж	943,138,00
1.1.6.	Бэлчээрийн усан хангамж, бэлчээр нөхөн сэргээх, хашиж хамгаалах, малын эрүүл мэнд, үржлийн	Мал бэлчээрлэх, МАА-г хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.	138000 толгой мал бэлчээрлүүлэх, халдварт өвчнөөс	50,000,00

	арга хэмжээний зардал		урьдчилан сэргийлэх	
1.2.	Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил			0,00
1.3.	Их засвар			1,216,300,00
1.3.1.	Орон сууцны дээвэр, заадасны завсар	Оршин суугчдыг ая тухтай оршин суух нөхцөлөөр хангана.	Орон сууцны бүх хороололд	500,000,00
1.3.2.	Сум, багуудын ажлын байр, цахилгаан гэмтэл, галын дохиоллын засвар, гадна тохижилт, гэрэлтүүлэг	Гадна талбайн болон ажлын байрны нөхцөл сайжирна.	Сумын ЗДТГ, 19 багийн	86,300,00
1.3.3.	Орон сууцны сан техник, цахилгааны засвар	Оршин суугчдыг ая тухтай оршин суух нөхцөлөөр хангах.	Орон сууцны бүх хороололд	370,000,00
1.3.4.	Зураг төсөв	Хөтөлбөр, төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Тухайн жилд болон ирэх жилийн хэрэгжүүлэх зарим ажлын хэмжээгээр	260,000,00

---0o0---

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
6 дахь удаагийн сонгуулийн ээлжит III хуралдааны
05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая, төгрөг/
1	Засаг дарга	
1.1.	Хөрөнгө оруулалт	1,427,138,00
1.1.1.	Гэр хорооллын багуудын гудамж, талбайн гэрэлтүүлэг хийх	200,000,00
1.1.2.	Үерийн усанд эвдэгдсэн газар ус зайлуулах, далан суваг сэргээн засварлах	50,000,00
1.1.3.	Ирээдүйн-Одод сургуулийн спорт заалны барилгын дутуу ажлын гүйцэтгэл	100,000,00
1.1.4.	Нийтийн аж ахуйн үйлчилгээний зориулалтаар гэр хорооллыг ундны усаар хангах зөөврийн усны автомашин	84,000,00
1.1.5.	Орон сууцны хорооллын байр хооронд 8-аас доошгүй газарт амралт, чөлөөт цагийн талбайтай ногоон байгууламж бүхий иж бүрэн тохижилтийг хийх	943,138,00
1.1.6.	Бэлчээрийн усан хангамж, бэлчээр нөхөн сэргээх, хашиж хамгаалах, малын эрүүл мэнд, үржлийн арга хэмжээний зардал	50,000,00
1.2.	Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	-
1.3.	Их засвар	1,216,300,00
1.3.1.	Орон сууцны дээвэр, заадасны завсар	500,000,00
1.3.2.	Сум, багуудын ажлын байр, цахилгаан гэмтэл, галын дохиоллын засвар, гадна тохижилт, гэрэлтүүлэг	86,300,00
1.3.3.	Орон сууцны сантехник, цахилгааны засвар	370,000,00
1.3.4.	Зураг төсөв	260,000,00
Нийт дүн		2,643,438,00

---0o0---



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

**Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдуулан
сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тогтоох тухай**

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1.1 дах заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит XXI хуралдаанаар баталсан 2012 оны 09 сарын 02-ны өдрийн “Тэргүүлэх чиглэл тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын
ИТХ-ын ээлжит III хуралдааны
06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ ОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН СУМЫН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Баян-Өндөр сумын хөгжлийн стратеги, хүн ам зүй, зах зээлийн багтаамж эрэлт хэрэгцээг үндэслэн дараах 3 чиглэлээр дэмжин хөгжүүлнэ. Үүнд:

1. Орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн, экологийн, эрүүл хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, савлах, хадгалах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
2. Импортыг орлох экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
3. Стандартад нийцсэн барилгын материалын жижиг үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
4. Нийтийн ахуйн үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.

--000--



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 07

Эрдэнэт

Зээлийн хэмжээ, хүү, хугацааг тогтоох тухай

Монгол улсын засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.6.1, 1.6.2, 3.1.2, 3.1.3 дахь заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 10 000 000 /арван сая/ төгрөг хүртэл тогтоосугай.

2.Сум хөгжүүлэх сангийн олгох зээлийн хүүгийн хэмжээг жилд 2.8%-иар тогтоосугай:

3.Зээлийг 36 сар хүртэл хугацаагаар олгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит XIV хуралдааны 2011 оны 06 сарын 14-ний өдрийн “Зээлийн хэмжээ, хүү, хугацаа тогтоох тухай” 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 08

Эрдэнэт

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч:

1.Сумын Засаг дарга

Нарийн бичиг:

2.СЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан

ажилтан

Гишүүд:

3.СЗДТГ-ын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан

4.Баг хариуцсан ажилтан

5.Иргэн А.Батмөрөн

6.Иргэн Л.Дашдаваа

7.Иргэн Ю.Мягмаржаргал

2.Зөвлөлийн ажилд гишүүдийн оролцсон байдлыг жил бүр дүгнэж, гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байхаар тогтоосугай.

3.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн ахлагч /И.Баасанжав/-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит XIV хуралдааны 2011 оны 06 сарын 14-ний өдрийн “Орон тооны зөвлөл байгуулах тухай” 04 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 09

Эрдэнэт

**Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах
зөвлөлийн ажиллах журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18, 25 дугаар зүйлийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн ажиллах журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг Зөвлөлийн ахлагч /Сумын Засаг дарга/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит XXI хуралдаанаар баталсан 2012 оны 09 сарын 02-ны өдрийн “Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн ажиллах журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын
ИТХ-ын ээлжит III хуралдааны
09 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1.Энэхүү журам нь суманд жижиг, дунд үйлдвэр, хоршоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2.Сан нь төрийн санд тусгай данстай байх бөгөөд гадуур данстай байхыг хориглоно.
- 1.3.Сангийн орлого зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ улирал жилийн тайлан тэнцэлд тусгагдана.
- 1.4.Иргэн, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сум хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна.
 - 1.4.1.Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ жилд 2,8 хувь
 - 1.4.2.Зээлийн хугацаа нь 36 сар хүртэл
 - 1.4.3.Нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ 10 сая төгрөг хүртэл
 - 1.4.4.Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсвэл зээлийн хөрөнгийн зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээг зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд хоногийн 0,5% -аар тооцож, дансанд төвлөрүүлж, зээлийн эх үүсвэрт зарцуулна.
 - 1.4.5.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй, арилжааны банк, бусад санхүүгийн байгууллагад тэтгэврийн болон цалингийн зээлээс бусад зээлийн өргүй байх
 - 1.4.6.Зээлийг олгохдоо зээлдэгчтэй зээлийн гэрээ болон барьцааны гэрээ, баталгааны гэрээ байгуулан олгох
 - 1.4.7.Зээлийн хэмжээнд тохирсон хөрөнгийг барьцаалах
 - 1.4.8.Тухайн зээлдэгч өөрийн барьцаалах хөрөнгө байхгүй тохиолдолд гуравдагч этгээдийн үл хөдлөх хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу барьцаанд тавьж болно.
- 1.5.Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
 - 1.5.1.Зөвлөлийн ахлагч – Сумын Засаг дарга
 - 1.5.2.Зөвлөлийн гишүүд нь сумын ЗДТГ-ын 3 мэргэжилтэн, тухайн сумын 3 иргэний төлөөлөл байна.
 - 1.5.3.Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд сонгон шалгаруулалт хийж, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
 - 1.5.4.Зөвлөл нь Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээлэл гаргах, хяналт тавих, төрийн сантай харилцах ажлыг хариуцсан нягтлан бодогчтой байна.
 - 1.5.5.Нягтлан бодогчийн урамшууллыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс олгохоор гэрээнд тусгана.

Хоёр.Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

- 2.1.Зөвлөлийн ахлагч сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.1.1.Зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах
 - 2.1.2.Төсөл нь шалгарсан иргэн аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах

- 2.1.3.Зээлийн хүүгийн орлогоос зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулах
- 2.1.4.Сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах
- 2.1.5.Багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх
- 2.2.Зөвлөлийн нарийн бичиг сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2.1.Өргөдлийн маягтыг хүлээн авч бүртгэлжүүлэх
- 2.2.2.Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг сар бүрийн 5-ны дотор гаргаж аймгийн Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэх
- 2.2.3.Зээлдэгчийн талаар гаргасан багуудын төрөлжсөн судалгааны дагуу айл өрх, аж ахуй нэгжээр биечлэн орж, мэдээний үнэн бодит байдалд хяналт тавих
- 2.2.4.Төсөл нь тэнцээгүй иргэдэд хариуг бичгээр хүргүүлж, тайлбар хийх
- 2.2.5.Өргөдлийн хариуг багийн Засаг даргаар дамжуулан хүргүүлэх
- 2.2.6.Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулах
- 2.3.Зөвлөлийн гишүүд сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.3.1.Зөвлөлийн гишүүд нь өргөдөл, төслүүдийг хүлээн авч газар дээр нь очиж танилцан, үнэлгээ хийх.
- 2.3.2.Улс, орон нутгийн бодлого, чиглэлд уялдуулан сонгон шалгаруулалтыг хийх
- 2.4.Зөвлөлийн нягтлан бодогч нь сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.4.1.Өргөдлийн маягтыг хүлээн авч бүртгэлжүүлэх
- 2.4.2.Сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал жил сараар гаргаж улирлын эхний сарын 10-ны дотор аймгийн төрийн сан, статистикийн хэлтэс, хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэх.
- 2.4.3.Зээлдэгч этгээдийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх, сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор төрийн сантай харилцах
- 2.4.4.Зээлдэгч хугацаандаа зээлийг төлөөгүй тохиолдолд хугацааны хувьд төлөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж, сангийн дансанд төвлөрүүлэн, зээлийн эх үүсвэрт зарцуулах
- 2.4.5.Зээлдэгчийн хувийн хэргийг бүрдүүлж, хөтлөх
- 2.4.6.Зөвлөлийн төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зээлийн хүүгийн орлогын 50 хувийг зарцуулна.
- 2.5.Багуудын ажлын алба сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.5.1.Багийн нийгмийн ажилтан сумын нарийн бичгийн хүлээлгэн өгсөн өргөдлийн маягтыг бодит байдал дээр нь очиж судалж, маягт дахь хэсэгт тодорхойлолтыг бичих
- 2.5.2.Багийн Засаг дарга тодорхойлолттой танилцаж үнэн бодитой эсэхийг тамга тэмдэгээр баталгаажуулан зөвлөлийн нарийн бичигт хүргүүлнэ.
- 2.5.3.Сангаас зээл авсан иргэн, аж ахуй нэгжүүдэд багийн нийгмийн ажилтан хяналт тавьж, улирал бүрийн дараа сарын 5 –ны дотор зээлдэгчийн судалгааг гаргаж зөвлөлийн нарийн бичигт хүргүүлж байх.

Гурав.Төсөл сонгон шалгаруулах

- 3.1.Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийг баримтлан ажиллана.
- 3.2.Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах үе шаттайгаар төслийг сонгон шалгаруулна.

- 3.2.1.Өргөдлийг маягтыг зөвлөлийн нарийн бичиг иргэн, аж ахуйн нэгжээс хүлээн авах
- 3.2.2.Зөвлөлийн гишүүд өргөдлийн маягттай танилцаж, харъяа багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгч тодорхойлолт гаргуулах
- 3.2.3.Тодорхойлолт гаргасан өргөдлүүдийг зөвлөлийн хурлаар дахин хэлэлцэж үнэлгээ хийж, төсөл ирүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг тодруулах
- 3.2.4.Ирсэн төслийн бичиг баримт болон төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай биечлэн танилцах
- 3.2.5.Зөвлөлийн хурлаар зээл олгох төслүүдийг олонхийн саналаар сонгон шалгаруулах
- 3.2.6.Шалгарсан төслүүдэд сумын Засаг дарга захирамж гарган, зээлдэгчтэй зээлийн гэрээ барьцааны гэрээ болон баталгааны гэрээ байгуулан зээлийг олгоно.
- 3.3.Олонхийн санал авсан төсөл гэдэгт 4 ба түүнээс дээш гишүүдийн санал авсан төслийг хамааруулж ойлгоно.
- 3.4.Төсөл сонгон шалгаруулах хурлыг бүх гишүүдийн 71% хувиас доошгүй ирцтэй тохиолдолд хийнэ.
- 3.5.Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараах шалгуурыг харгалзан үзнэ.
 - 3.5.1.Сумын ИТХ –с баталсан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байх
 - 3.5.2.Тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх
 - 3.5.3.Хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх
 - 3.5.4.Төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх
 - 3.5.5.Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх
 - 3.5.6.Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх
- 3.6.Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.6.1.Арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагад бизнесийн зээлийн өргүй байх
 - 3.6.2.Үйл ажиллагаагаа өргөтгөх, нэмэгдүүлэх зорилготой иргэн, аж ахуй нэгжүүд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэгдсэн байх.
 - 3.6.3.Зөвлөлийн хурлаар баталсан зээлийн гэрээний 2.6 дах заалтын шалгуур хангасан батлан даагчтай байх
 - 3.6.4.Зээлийн хэмжээнд тохирсон барьцаатай байх.

Дөрөв.Хариуцлагын тухай

- 4.1.Батлан даагч нь зээлдэгчийн зээлийн зарцуулалт, нөхөн төлөлт, үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд баталгааны гэрээнд заасны дагуу зээлдэгчийн өмнөөс бүрэн хариуцлага хүлээнэ.
- 4.2.Зээлдэгч зээлийг үр ашиггүй зарцуулсан эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуй нэгж нь зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 4.3.Сангийн хөрөнгийг зарцуулах зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ III ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 10

Эрдэнэт

Хяналтын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1.5 дах заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагчаар:	Б.Оюунбилэг
Гишүүдээр:	Бо.Ганболд
	П.Хишигжаргал
	Ч.Өлзийбаяр
	Б.Батсайхан
	С.Ганцогт
	М.Энхбат

2.Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэнд тухайн санхүүгийн жилд журамд заасны дагуу 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байхыг ажлын хэсгийн ахлагч /Б.Оюунбилэг/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын ээлжит XIV хуралдааны 2011 оны 06 сарын 14-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

**Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны
төсвийг шинэчлэн батлах тухай**

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 27-ны 134 дүгээр тогтоолын 1-р хавсралт, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмын 1.8, 3.2.6 дахь заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит IV хуралдаанаас **ТОГТООХ**нь:

1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал тутам Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд мэдээллэж байхыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн ээлжит II хуралдааны 2012 оны 12 сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоол, III хуралдааны 2013 оны 01 сарын 31-ний өдрийн 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 03

Эрдэнэт хот

**Сумын Газар зохион байгуулалтын
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18, 25 дугаар зүйлүүдийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, төлөвлөгөөний хавсралтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Засаг дарга И. Баасанжавт ДААЛГАХ нь:

2.1 Иргэдэд газар өмчлүүлэх ажлын хуулийн хүрээнд зохион байгуулж, төлөвлөгөөний биелэлт, зохион байгуулсан ажлын үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд бүтэн жилээр мэдээлж байх

2.2 Монгол Улсын Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулах

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын
29-ний өдрийн ээлжит IV хуралдааны
01 дугаар тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН 2013 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлын үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
0	1	2	3	4
1	Газар зохион байгуулалтын ажлыг хуулийн хүрээнд оновчтой зохион байгуулах	1.1 Иргэн бүрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Их залуу, Эрдэнэ, Говил, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт 550 иргэнд 44 га газар шинээр болон нөхөн эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах /Хавсралт 1/	2,3-р улиралд	Сумын Засаг дарга Газрын даамал
		1.2 Ногооны талбайн зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах /Хавсралт 2/	Жилдээ	Сумын Засаг дарга Газрын даамал
		1.3 ХАА-н сургалт туршилтын төв байгуулах газрыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах /хавсралт 3/	2,3-р улиралд	Сумын Засаг дарга Газрын даамал МЭҮТасаг
		1.4 Төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах /Хавсралт 7/	Жилдээ	ГХБХБГ Газрын даамал
2	Газрын кадастрын талаар	2.1 Газар ашиглагч эзэмшигч, өмчлөгчдийн улсын бүртгэлийг хөтөлж, газрын кадастрын мэдээллийн санд баяжуулалт хийх	Жилдээ	ГХБХБГ Газрын даамал
		2.2 Газар эзэмшигч, ашиглагчдаас газрын төлбөр авах ажлыг зохион байгуулах	Жилдээ	ГХБХБГ Газрын даамал
		2.3 Сумын өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэн, гэрчилгээжүүлэх	2-р улиралд	ГХБХБГ Сумын Засаг дарга
		2.4 Нийтийн эзэмшлийн талбайг кадастрын нэгдсэн санд оруулж, баталгаажуулах	Жилдээ	ГХБХБГ, МХГ Сумын Засаг дарга Газрын даамал
3	Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтэд хяналт	3.1 Газрын харилцааны зөрчил маргааныг судлан дүн шинжилгээ хийж хууль тогтоомж зөрчигчтэй хариуцлага тооцож, зөрчлийг арилгуулах ажлыг тухай бүр хийж хэрэгжүүлэх /Хавсралт 4/	Жилдээ	МХГ, ГХБХБГ Сумын Засаг дарга БОХ-ын байцаагч
		3.2 Гэр хорооллын гудамж, зам талбайн газарт буусан айл өрхүүдээр газар чөлөөлүүлэх арга хэмжээг зохион байгуулах /Хавсралт 5/	1,2-р улиралд	ГХБХБГ Сумын Засаг дарга

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

	тавьж, хууль сурталчлах ажлыг зохион байгуулах талаар	3.3 Эрдэнэ, Дэнж багийн шинээр тавигдах авто замын трассын газрыг чөлөөлөх, эзэмшиж, өмчилж байгаа газар нь замын трасст өртсөн иргэдэд нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах	жилдээ	БОХ-ын байцаагч ГХБХБГ, МХГ Сумын Засаг дарга Газрын даамал
		3.4 Газрын тухай багц хуулийг иргэд, олон нийтэд сурталчлах, сургалт явуулах ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Жилдээ	ГХБХБГ Газрын даамал
4	Газар өмчлөлийн ажлыг хэрэгжүүлэх талаар	4.1 Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлж сумын нутаг дэвсгэрт иргэний гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх / Хавсралт 6 /	Жилдээ	ГХБХБГ Сумын Засаг дарга
		4.2 Иргэдийн гэр бүлийн хамтын хэрэгцээнд өмчлүүлсэн газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж бусад гишүүдэд хууль тогтоомжид заасан иргэн бүр нэг удаа үнэгүй газар өмчилж авах эрхийг хуулийн хүрээнд зохион байгуулах	Жилдээ	ГХБХБГ Сумын Засаг дарга
5	Газрыг хамгаалах, элэгдэл, эвдрэлийг багасгах, нөхөн сэргээх ажлын талаар	5.1 Гэр хороололын хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу Уртбулагын голын гольдролын дагуух газрыг хамгаалж цэцэрлэгжүүлэх /Хавсралт 8/	2-р улиралд	БОАЖГ, МХГ ГХБХБГ Сумын Засаг дарга

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗДТГ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдааны 2-р хавсралт

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН 2013 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТУУД

Эрдэнэт хот
2013 он

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 1

2013 ОНД ИРГЭНД ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР НӨХӨН ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил буюу хаяг	Эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Өрхийн тоо	Газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцах эзэн
							I	II	III	IV	
1	Баян-Өндөр	Их Залуу	Хуучин ХАБИТАТ-ын баруун талд, Самбартай хөтөл явдаг замын дагуу /нөхөн олголт /	0.08	400	32					ГХБХБГ Сумын Засаг дарга, газрын даамал,
2		Эрдэнэ	Бүрэнбүстийн овооны зүүн хойд хэсэгт /нөхөн олголт/		120	9.6					
3		Говил	35-р баазын хойд энгэрт /нөхөн олголт/		20	1.6					
ДҮН					540	43.2					

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 2

НОГООНЫ ТАЛБАЙН ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил буюу хаяг	Эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Өрхийн тоо	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Баян-Өндөр	Эрдэнэ	Эрдэнэ багийн байрны баруун талд	3,3	1	жилдээ	ГХБХБГ Сумын Засаг дарга, газрын даамал
2		Малчин	Баянцагааны өвөрт	3.2	1		
	Дүн			6.5	2		

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 3

ХАА-Н СУРГАЛТ ТУРШИЛТЫН ТӨВ БАЙГУУЛАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил буюу хаяг	Эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Баян-Өндөр	Малчин	Баянцагааны өвөрт өвс тэжээлийн агуулахын ард	1	2, 3-р улирал	Засаг дарга МЭҮТасаг Газрын даамал
	Дүн			1		

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.

ХАВСРАЛТ № 4

ГАЗРЫН ЗӨРЧИЛ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР

№	Багийн нэр	Байршил	Зөрчлийн байдал	Өрхийн тоо	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Рашаант	Ногооны талбайн урд	Гэр хорооллын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд айл өрхийг суурьшуулахаар төлөвлөгдөж буй газар	30	Ерөнхий төлөвлөгөөний зам талбайг гаргаж, гудам талбайг нь зохион байгуулж, зөрчил гарган дураараа буусан иргэдийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх	2, 3-р улирал	МХГ, ГХБХБГ-н холбогдох мэргэжилтэн Сумын газрын даамал
2	Их залуу	Хабитатын 13-р гудамжны зүүн үзүүрт		14			
3	Баянбулаг	Баян-Өндөрийн 2, 3-р хэсгийн хойд хэсэг		28	зам талбайг гаргаж, гудам талбайг нь зохион байгуулж, зөрчил гарган дураараа буусан иргэдийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх		
4	Баянбулаг	Баян-Өндөрийн 3-р хэсгийн урд	Гэр хорооллын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Ногоон бүс айл өрх суурьших боломжгүй газар	10	Засаг даргын захирамжаао албадан чөлөөлөх		
		Дүн		82			

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 5

НИЙТИЙН ЭДЭЛБЭРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАРЦЫГ ЧӨЛӨӨЛЖ, НАРИЙН ГУДАМ ГАРГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Багийн нэр	Байршил	Шийдвэрлэх арга хэмжээ	Газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцах эзэн
					I	II	III	IV	
1	Рашаант	Ногооны талбайн урд	Гудамж, гарц гаргана	0.07					Сумын Засаг дарга, газрын даамал, ГХБХБГ-н газар зохион байгуулагчид
2	Баянцагаан	Шугам сүлжээний урд		0.06					
3	Дэнж	Нарлаг дэнж 8-р гудамж		0.08					
дүн				0.21					

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 6

ИРГЭНД ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ , ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Багуудын нэр	Өмчлүүлэх өрхийн тоо	газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
0	1	2	3	4	5	6
1	Баян-Өндөр сум	Баянбулаг	20	2	Жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал, Багуудын засаг дарга нар, аймгийн газрын албаны холбогдох мэргэжилтэн
2		Булаг	20	2		
3		Цагаанчулуут	25	2,5		
4		Рашаант	45	3,6		
5		Наран	26	2,6		
6		Шанд	75	6		
7		Их залуу	190	15,2		
8		Дэнж	35	2,8		
9		Эрдэнэ	65	5,2		
10		Говил	35	3,5		
11		Баянцагаан	32	2,56		
	Дүн		568	47,96		

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВСРАЛТ № 7

ТӨРИЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗАР

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Эзэмшүүл эх хугацаа	Хэрэгжүүл эх хугацаа	Эзэмшүүлэх хэлбэр	Хариуцах эзэн
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Баян-Өндөр	Их залуу	Яргуйтын хэсэгт	0,15	Багийн байр	15	Жилдээ	Засаг даргын захирамжаар	ГХБХБГ Баян-Өндөр сум
2		Рашаант	Уртын голын хэсэгт	0,15	Багийн байр	15	Жилдээ	Засаг даргын захирамжаар	ГХБХБГ Баян-Өндөр сум
3		Шанд	Шанд багийн нутаг дэвсгэрт	0,15	Багийн байр	15	Жилдээ	Засаг даргын захирамжаар	ГХБХБГ Баян-Өндөр сум
	Дүн			0,45					

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 03 сарын 29-ний өдрийн
Ээлжит IV дүгээр хуралдаанаар батлав.
ХАВЦРАЛТ №8

ГАЗРЫН ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛ, ДОРОЙТЛООС ХАМГААЛАХ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Багийн нэр	Байршил	Хийх ажил	Газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцах эзэн
					I	II	III	IV	
1	Дэнж	Рашаант баг, Эрдэнэт-Булганы автозамын урд талд	Цэцэрлэгт хүрээлэн	8					БОАЖГ, ГХБХБГ Сумын Засаг дарга, газрын даамал
5	ДҮН			8					



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 04

Эрдэнэт хот

**Бэлчээрийн менежментийг төлөвлөгөөг
батлах тухай**

Монгол Улсын Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.6, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. 2013 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, туршилтын төв байгуулах төсөл, зургийг 2 дугаар хавсралтаар, малчдын өвөлжөөний доорхи газрыг эзэмшүүлэх судалгаа, зургийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг чанартай зохион байгуулж, 4 дүгээр улиралд танилцуулахыг Баян-Өндөр сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
6 дахь удаагийн сонгуулийн 2013 оны 03 сарын 29-ний
ээлжит IV хуралдааны 4 дугаар тогтоолын 2-р хавсралт

**МАЛЧИН ӨРХ ТЭДГЭЭРИЙН ӨВӨЛЖӨӨНИЙ ДООРХИ ГАЗРЫГ
ЭЗЭМШҮҮЛЭХ СУДАЛГАА**

№	Малчдын нэрс	Малын төрөл						Өвөлжөө хаваржааны доорхи газрын эзэмшлийн байдал	
		Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Газрын оноосон нэр	Усан хамгамжийн нэр
1	Д.Даваа	2			2			Баянцагаан	Худаг ,булаг
2	Г.Баасанбямба	3			3			Баянцагаан	Худаг ,булаг
3	Д.Бямбажав	4			4			Арбулаг	Булаг
4	Ц.Аюурзана	28			23		5	Баянцагаан	Худаг ,булаг
5	А.Батцэцэг	6			6			Баянцагаан	Худаг ,булаг
6	Ц.Мягмарсүрэн	7			7			Арбулаг	Булаг
7	З.Ванчинхүү	9			9			Булаг	Булаг
8	П.Моломжамц	8			8			Баянцагаан	Худаг ,булаг
9	Д. Давааням	23				3	20	Булаг	Булаг
10	Ц.Галя	13			13			Баянцагаан	Худаг ,булаг
11	Г.Онхор	13			13			Арбулаг	Булаг
12	П.Цэрэндорж	20			20			Хутагийн баруун шанаа	Гол
13	Д.Пүрэв	16			16			Баянцагаан	Худаг ,булаг
14	Л.Бадам	24			24			Баянцагаан	Худаг ,булаг
15	Б.Батзориг	27					27	Баянцагаан	Худаг ,булаг
16	Ж.Дашвандан	111			13	26	72	Баянцагаан	Худаг ,булаг
17	Ж.Одбаатар	234		24	19	84	107	Ар булаг	Булаг
18	П.Цэрэндаваа	181		13	34	111	23	Их хөтөл	Гол
ДҮН		729		37	214	224	254		



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ V ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

ОНХС-ын зарцуулалтын тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 64 дүгээр зүйлийн 64.1.2, 64.1.4 дэх заалт, ОНХС-гийн зарцуулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнгийн тухай Сумын Засаг даргын мэдээллийг хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1.Сумын ОНХС-гийн хөрөнгийн төсвөөр 2013 онд гүйцэтгэсэн хөтөлбөр арга хэмжээг батлагдсан хуваариар төсөвт өртөгт багтаан зориулалтын дагуу **ХАНГАЛТТАЙ** гүйцэтгэсэн гэж дүгнэсүгэй.

2.Сумын Засаг дарга-д даалгах нь:

2.1.Дараа онд гүйцэтгэх хөтөлбөр төсөл арга хэмжээг багийн иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлсний дагуу санхүүжүүлэх

2.2.Хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техникийн даалгавар, зардлыг зураг төсөвт үндэслэн оновчтой төлөвлөн, төсвийг батлуулах

2.3.Багийн нутаг дэвсгэрт хэрэгжих хөтөлбөр арга хэмжээний талаар тойргоос сонгогдсон хурлын Төлөөлөгчдөд мэдээлэл өгөх, харилцан ажлын уялдаатай ажиллах

3.Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ОНХС-гийн зарцуулалт гүйцэтгэлийг жилд хурлын хуралдаанд 4 удаа танилцуулахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ V ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

2013 оны ОНХС-н төсөвт
тодотгол хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64 дугаар зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн ажлаас хэмнэгдсэн дээврийн засвар шинэчлэхэд зарцуулахаар төлөвлөсөн 210.067.336 /Хоёр зуун арван сая жаран долоон мянга гурван зуун гучин зургаан/ төгрөгийг гэр хорооллын Их залуу, Шанд, Эрдэнэ багийн айл өрхийн цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлэхэд зарцуулахаар тодотгож төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Их залуу, Шанд, Эрдэнэ багийн айл өрхийн цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлэхээр тодотгосон 199.950.284 /Нэг зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянга хоёр зуун хаян дөрвөн/ төгрөгийг зарцуулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг 2013 онд багтаан Сумын хурлын хурадаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ V ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Сум хөгжүүлэх сангийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Засгийн газрын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам батлах тухай 134 дүгээр тогтоол, Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, эргэн төлөлт ашиглалтын явцын тухай сумын Засаг даргын мэдээллийг хэлэлцээд ТОГТООХ нь:

НЭГ.Сумын Засаг даргад даалгах нь:

1.1.Сум хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг дахин тодорхойлж, бага орлоготой иргэдийн өрхийн болон жижиг үйлдвэрлэл эрхлэх зорилгод нийцүүлэх

1.2.Иргэдээс төсөл хүлээн авах сонгон шалгаруулах зээл олгох үйл ажиллагааг журамд нийцүүлэн хүнд сурталгүй, чирэгдэлгүй, шуурхай нээлттэй зохион байгуулах

1.3.Зээл хүсэж иргэдээс ирүүлсэн төслийг сонгоход тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхой, иргэдэд ойлгомжтой болгож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах

1.4.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, улирал бүр хариу мэдэгдэх

ХОЁР.Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зээл олголт, ашиглалт, эргэн төлөлтийн явцын талаар улирал бүр Тэргүүлэгчдийн хуралдаанд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Сумын нутаг дэвсгэрт 2014 онд ОНХС-гийн
хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээг
эрэмбэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63, 3, 63,4 дэх заалт, багийн Иргэдийн нийтийн хурал дээр гаргасан саналыг тэргүүлэх ач холбогдлоор нь төсөл арга хэмжээг эрэмбэлсэн тухай сумын Засаг даргын илтгэлийг сонсоод Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн саналыг тусган 2014 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэ дарааллыг I хавсралтаар, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд тусган 2014 онд хийгдэх ажлын жагсаалтыг II хавсралтаар, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх иргэдээс гарсан ажлын дарааллыг III хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрэмбэлсэн саналын дагуу 2014 оны төсвийн төслийг боловсруулах, ОНХС-гийн төсөв батлуулах, гүйцэтгэлийг зохион байгуулж, хуралдаанд хагас бүтэн жилээр тайлагнахыг Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 11 сарын 22-ны өдрийн ээлжит
VI хуралдааны 2-р тогтоолын I хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДЭЭС 2014 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН САНАЛ

2013.11.20

2015.11.20

№	Асуулга	Багийн нэр																		Дүн	
		Зэст	Оюут	Уурхайчин	Хүрэнбулаг	Уртбулаг	Бүрэнбүст	Согоот	Дэнж	Эрдэнэ	Наран	Булаг	Баянбулаг	Цагаанчулуут	Рашаант	Шанд	Баянцагаан	Говил	Малчин		Их залуу
1	Гэрэлтүүлэг	73	202	62	85	245	200	250	200	180	108	400	141	320	210		200	300		130	3306
2	Хүүхдийн тоглоомын талбай	19	747	150	66	250	121		120		76	250		177			456	553			2985
3	Камержуулах	78	200	60	80	200	150	230	215	180	100	368	80	250	190		130	150		100	2761
4	Үерийн усны суваг шуудуу сэргээн засварлах ус зайлуулах хоолойг засварлах						96	259	2			360	10	360	100	55	415	574		112	2343
5	Дээвэр, заадасны засвар	70	373	123	159	350		284									80				1439
6	Багт хогийн машин авах								22		66	350		478	382						1298
7	Хогийн сав	63	236	75					172			150						358			1054
8	Явган хүний замыг засварлах		72		69	200	136						16	219			256			86	1054
9	Автомашин, зам, гүүр, гарам, явган хүний гарц хийх								195			200		208				255	34		892
10	Хашаа гудамж, хаалганы хаягжилт хийх								54	129	69	300			145						697

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ 2013

11	Орон сууцны байрнуудын сантехникийн засвар	30	305		31			110	117											593
12	Интернет, сүлжээ							377									106			483
13	орон сууцны байрнуудын орцны хаалгыг кодтой болгох			16 5		300														465
14	Цахилгааны трансматор								21		92			164		14 7				424
15	Халуун ус шинээр барих									155			20			15 2	80			407
16	Байшингийн хавч	368																		368
17	Ногоон байгууламжийг сэргээн засварлах	50	39						51			120								260
18	Худаг, усан сан барих								115							12 2			22	259
№	Асуулга	Багийн нэр																		Дүн
		Зэст	Оюут	Уурхайчин	Хүрэнбулаг	Уртбулаг	Бүрэнбүст	Согоот	Дэнж	Эрдэнэ	Наран	Булаг	Баянбулаг	Цагаанчулуут	Рашаант	Шанд	Баянцагаан	Говил	Малчин	
19	Гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах								4		72	30	30		100					236
20	Гэр төсөл хэрэгжүүлэх											206								206
21	Эрүүл мэндийн төвийн цэвэр усны асуудал шийдэх									143	52									195
22	Багийн ажлын албаны хэрэгцээнд ашиглах авто машинтай болгох									155										155
23	Цахилгааны шит засах							125												125

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ 2013

24	Өрхийн эмнэлэгт зүрхний бичлэг, шарлагын аппарат,агааржуулалтын систем шинээр тавих									120											120
25	Иргэний танхимыг шинээр байгуулж тохижуулах										113										113
26	Шинээр газар авч хашаа барьсан айл өрхүүдийн дэд бүтцийн асуудал шийдэх																	34			34
27	Подволны засвар	10			13				10												33
28	Багуудын гэрлэн хаягийг шинэчлэх								30												30
29	Малчид мах сүүгээ ченжээр дамжуулахгүй өөрсдөө борлуулдаг цэгтэй болгох																		29		29
30	Спорт заал												27								27
31	7-р сургуулийн урд машины зогсоол барих								18												18
32	Эко халаагуур тавих								10												10
	Дүн	761	2174	635	503	1545	703	1635	1356	1062	748	2734	324	2176	1127	476	1617	2330	85	428	22419

Баян-Өндөр сумын хэмжээнд 11400 ширхэг саналын хуудас тарааж 11400 ширхэг саналын хуудас хүлээн авсан. Нийт дүн давхардсан тоогоор

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 11 сарын 22-ны өдрийн ээлжит
VI хуралдааны 2 –р тогтоолын II хавсралт

2014 ОНД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН САНАЛ АВАХ ҮЕД ИРГЭДЭЭС ГАРГАСАН САНАЛ
шаардахгүй, хууль эрх зүйг үндэслэж зохион байгуулах ажил/

/хөрөнгө мөнгө

2013.11.20

2019.11.20

№	Асуулга	Багийн нэр																		Дүн	
		Зэст	Оюут	Уурхайчин	Хүрэнбулаг	Уртбулаг	Бүрэнбүст	Согоот	Дэнж	Эрдэнэ	Наран	Булга	Баянбулаг	Цагаанчулуут	Рашаант	Шанд	Баянцагаан	Говил	Малчин		Их залуу
1	Хог ачилтыг тогтмолжуулах					325														71	396
2	СӨХ-ийн ажлыг сайжруулах	68	56	156																	280
3	40-өөс дээш насныханд ажлын байр нэмэгдүүлэх, сургалтанд хамруулах			91					112												203
4	Баг хуваах			97																	97
5	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, зээлийг хүртээмжтэй болгох			30					61												91
6	Багийн цагдаагийн ажлыг сайжруулах	38	45																		83
7	Орон сууцны үнэ бууруулах								62												62

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ 2013

8	Багийн ажлын албаны байрыг төвд байрлуулах																		38		38
9	Цалин нэмэх							35													35
10	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих							32													32
11	Үнийн өсөлтийг барьж ажиллах							20													20
12	Түүцүүдийг нүүлгэх							18													18
13	Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах																		17		17
14	Газар эзэмших, малчдыг өөрсдийн гэсэн газартай болгох																		15		15
15	Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх							10													10
16	Хэсгийн ахлагч нарыг өрхүүдээр сайн явуулах							9													9
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дасгалын цагийг сунгаж 18 цагаас тарааж байх							4													4
18	Залуучуудыг ажилд идэвхитэй оролцуулах							2													2
	Дүн	106	101	374	0	325	0	0	365	0	0	0	0	0	0	0	0	0	70	71	1412

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2013 оны 11 сарын 22-ны өдрийн ээлжит
VI хуралдааны 2-р тогтоолын III хавсралт

2014 ОНД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН САНАЛ

2013.10.23

Эрдэнэт

№		Асуулга	Багийн нэр																		Дүн
			Зэст	Оюут	Уурхайчин	Хүрэнбулаг	Уртбулаг	Бүрэнбүст	Согоот	Дэнж	Эрдэнэ	Наран	Булаг	Баянбулаг	Цагаанчулуут	Рашаант	Шанд	Баянцагаан	Говил	Малчин	
1	Автозамын өргөтгөл, зогсоол	83	455	300		350	122	138				400	194				356	600			2998
2	Өрхийн эрүүл мэндийн төвийн байр		25						420			400	13		445						1303
3	Шинээр цэцэрлэг, сургууль барих	33	82	96							68		24		440			194		60	997
4	Утаагүй зуух								79		75	380					335				869
5	Доороо граж бүхий ногоон байгууламжтай хүүхдийн тоглоомын талбай		450					271													721
6	Ажлын байр нэмэгдүүлэх	108	68	38				310	112											62	698

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

7	Дэнж баг ажлын албаны тустай байртай болох							435											435
8	Согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүрийн тоог цөөрүүлэх			133		280													413
9	24 цагийн хөнгөлөлттэй үйлчилдэг эмийн сан													390					390
10	Соёлын төвийн барилга																365		365
11	Нэг цэгийн үйлчилгээний байртай болох													339				19	358
12	Гэр хорооллын айл өрхүүд руу халаалтын шугам татах									40							289		329
13	14-р сургуулийн өргөтгөлийг гүйцээж бариулах							230											230
14	Уртын голын хэсгээс хорооллын эцэс хүртэл нийтийн тээвэр явуулах													215					215
15	Орон тооны хэсгийн байцаагчтай болох			95				56											151
16	Орхон цогцолбор сургуулийн					120													120

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

	урлагийн заалны дээврийг засах																			
	Цахилгаан шат, хүчдэл шинэчлэх					103														103
17	Яргуйтын чиглэлийн замыг засах																	79		79
18	Орон сууцны байранд байрлах зочид буудлыг татан буулгах			65																65
19	Малчдын хүүхдүүдийн дотуур байртай болгох																47			47
20	гэр хороололын айл өрхүүдийг дулааны шугамтай холбох							20												20
21	Цэцэрлэгийн өргөтгөл барих							20												20
22	Дэнж багийг Соёлын төвтэй болох							6												6
23	Ахмадын байр											6								6
24	Алтан сан дэлгүүрийн урдуур, Тахилт нуур дэлгүүрийн хажуугаар нийтийн тээврийг бүрэн тойруулж байх							4												4

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

	Дүн	224	1080	727	0	750	225	949	1152	0	183	1180	237	0	1829	0	980	1159	66	201	10942
--	-----	-----	------	-----	---	-----	-----	-----	------	---	-----	------	-----	---	------	---	-----	------	----	-----	-------

НЭГТГЭЛ ХИЙСЭН БАГ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Б.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Төсөвт тодотгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын ОНХС-д 2013 онд батлагдсан төсвийн зардлын хэмнэлт 210 067 336 /Хоёр зуун арван сая жаран долоон мянга гурван зуун гучин зургаан/ төгрөг, зураг төсвийн зардал 260 000 000 /Хоёр зуун жаран сая/ төгрөгнөөс 198 142 664 /Нэг зуун ерэн найман сая нэг зуун дөчин хоёр мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөг нийт 408 210 000 /Дөрвөн зуун найман сая хоёр зуун арван мянган/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн шилжүүлсүгэй.

2.2013 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн сангаас 408 210 000 /Дөрвөн зуун найман сая хоёр зуун арван мянган/ төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийн
бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай

Монгол улсын Засгийн газрын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам батлах тухай 134 дүгээр тогтоолын 3.3 дахь заалт, Сумын Засаг даргын саналыг хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнээс С.Наранцэцэг, М.Энхсанаа А.Батмөрөн, Л.Дашдаваа, Ю.Мягмаржаргал нарыг чөлөөлсүгэй.

2.Дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож баталсугай. Үүнд:

- Балгансүрэнгийн Батжаргал /Сум хөгжүүлэх сангийн нябо/
- Батбилэгийн Батчимэг /СЗДТГ-ын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан/
- Санжидын Отгонцагаан /Иргэний төлөөлөл/
- Хүрэлбаатарын Адъяацогт /Иргэний төлөөлөл/
- Даваажаргалын Мөнхбат /Иргэний төлөөлөл/

3.Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг журмын дагуу ажлын удирдлагаар ханган ажиллуулж, гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

2013 оны үндсэн чиглэлийн
биелэлтийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1.Сумын эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг төлөөлөгчдийн олонхийн саналаар **ХАНГАЛТТАЙ** гэж дүгнэсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сумын эдийн засаг нийгмийг 2014 онд
хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Үндсэн чиглэлийн төслийг хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг I хавсралтаар баталсугай.

2. Сумын Засаг даргад даалгах нь:

2.1.Сумын Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан сумын эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг оновчтой төлөвлөх

2.2.Сумыг 2020 он хүртэл хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө, гэр хорооллын төлөвлөлтийг дахин хийж, 2014 оны IV улиралд багтаан батлуулах

2.3.Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын эх үүсвэрийг оновчтой тооцох

2.4.Сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээг иргэд, төлөөлөгчдийн саналыг тусган тодорхойлж, Улсын болон Орон нутгийн төсөв, ОНХС-г санхүүжүүлэх

3. Хурлын хуралдаан дээр төлөөлөгчдөөс гарсан саналыг үндсэн чиглэлд тусгах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит
VII хуралдааны 03 дугаар тогтоолын I хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Д/Д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Зардал: Эх үүсвэр
НЭГ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ ИРГЭДТЭЙ ИРГЭНШСЭН ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ 1.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх чиглэлээр:					
1.	1.1.1. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан эрхийн дагуу аж амьдрлын аливаа асуудлыг Ардчилсан нээлттэй байдлаар иргэд өөрсдөө шийдвэрлэж байхын тулд сумын дүрмийг нийтийн саналыг тусган боловсруулж батлан мөрдөнө.	1.1.1.1. Сумын дүрмийн төслийг батлаж, мөрдөх	Жилдээ	Засаг дарга БХА	Хөрөнгө шаардахгүй
2.		1.1.1.2. Засгийн газрын болон аймгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
3.	1.1.2. Иргэний танхим байгуулан суманд тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд санал асуулга явуулж хэлэлцүүлэн тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно.	1.1.2.1. ЗДТГ, баг бүрт иргэний танхим байгуулан шаардагдах техник хэрэгсэл, эд хогшлоор ханган иргэд санал хүсэлтээ илэрхийлэх, мэдээлэл авах, нөхцөл бүрдүүлэх	Жилдээ	Засаг дарга БХА	Орон нутгийн хөрөнгөөр
4.		1.1.2.2. Иргэдийн дунд нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалт, бусад тулгамдаж буй асуудлаар 2-оос доошгүй санал асуулга явуулж дүнг төсөл хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх	Жилдээ	Засаг дарга БХА	Орон нутгийн хөрөнгөөр
5.		1.1.2.3. Санал асуулгын дүнг үндэслэн иргэдээр хэлэлцүүлж хөтөлбөр төсөл арга хэмжээг эрэмбэлж тухайн жилд санхүүжүүлэх шийдвэр гаргах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга БХА, Багийн Засаг дарга нар	Хөрөнгө шаардахгүй
6.		1.1.2.4. Шинээр гарч буй хууль тогтоомж болон хуульд орсон нэмэлт өөрчлөлт хийгдсэнийг иргэдэд таниулах, зөвлөмж өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХЗАХА	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

7.		1.1.2.5. Шинээр байгуулагдсан багуудын үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд баг, цагдаа, өрхийн эрүүл мэндийн төв, Нэг цонхны үйлчилгээ бүхий цогцолбор байр барих	Жилдээ	БХА	Орон нутгийн төсвөөс
8.	1.1.3. Сум багийн үйл ажиллагааг ил тод болгож холбогдох шийдвэрүүдийг онлайн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж хяналт тавих эрхийг иргэдэд олгоно.	1.1.3.1. Багийн ИНХ-ыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж багийн Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсгийн тайлан хэлэлцүүлж үнэлэлт дүгнэлт өгөх	Хагас бүтэн жилээр	Засаг дарга БХА Багийн Засаг дарга нар	Хөрөнгө шаардахгүй
9.		1.1.3.2. Сумын ЗДТГ, багаас хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ, хөтөлбөр төслийн хэрэгжилтийг онлайн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах	Улирал бүр	Мэдээлэл хариуцсан ажилтан Багийн Засаг дарга нар	ЗДТГ-ын төсвөөс
10.		1.1.3.3. Сумын ЗДТГ веб сайт нээн баг бүр танилцуулга, гаргасан шийдвэр, ажлын үр дүнг сурталчлах иргэдийн санал гомдол үнэлэлт дүгнэлтийг хүлээн авах	Улирал бүр	Мэдээлэл хариуцсан ажилтан Багийн Засаг дарга нар	ЗДТГ-ын төсвөөс
11.		1.1.3.4. Иргэдийн өргөдөл санал гомдлыг нээлттэй утсаар авах, иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан хуулийн дагуу шуурхай хариу өгөх	Сар бүр	Өргөдөл гомдол хариуцсан ажилтан Багийн Засаг дарга нар	ЗДТГ-ын төсвөөс
12.		1.1.3.5. “Цахим-Баян-Өндөр” сум хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж сум, багийг цахим, онлайн системд холбож, “Иргэн төвтэй” төрийн цахим үйлчилгээг бий болгох	Жилдээ	Хэвлэл мэдээллийн ажилтан	ОНХСангаас
13.		1.1.3.6. Баян-Өндөр сумын тодорхой цэгүүдэд төрийн үйлчилгээний цахим машин /ТҮЦ/-ууд байрлуулж ажиллуулах	Жилдээ	Хэвлэл мэдээллийн ажилтан	ОНХСангаас
14.		1.1.3.7. Гэр хорооллыг интернетжүүлэх	Жилдээ	ЗДТГ-ын дарга БХА	ОНХСангаас
15.		1.1.3.8. Иргэд хүлээн авах төвийг сумын ЗДТГ-т байгуулах	Жилдээ	ЗДТГ-ын дарга ЗДО	ОНХСангаас
16.		1.1.3.9. МУ-ын Засгийн газраас батлагдсан Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг мөрдөж ажиллах	Жилдээ	БХА	ОНХСангаас
17.		1.1.3.10. Аймгийн баг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллах	Жилдээ	БХА	
18.		1.1.3.11. Сумын 20 жилийн ойд зориулсан арга	Эхний хагас	ЗД, ЗДТГ	Нөөц сангийн

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

		хэмжээг зохион байгуулах	жилд		хөрөнгөөр
19.	1.1.4. “Төсвийн ил тод байдал”-ыг хангах авлига хээл хахуулийг халах зорилгоор төсвийн мөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, ТББ иргэдийн оролцоотой ил тод явуулна.	1.1.4.1. Сум, багийн эдийн засаг, нийгмийн хэтийн хөгжил, хөрөнгө оруулалтыг тооцон төсвийг зардлын зүйл ангиар төлөвлөх, хуваарийн дагуу зарцуулж ил тод тайлагнах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
20.		1.1.4.2. Сум хөгжүүлэх сангийн зээлийг иргэдэд олгох ажлыг нээлттэй ил тод зохион байгуулах	Жилдээ	Төсөл сонгон шалгаруулах зөвлөл	Хөрөнгө шаардахгүй
21.	1.1.5. Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг баталж олон нийтийн хяналтын зөвлөл байгуулан ажиллана.	1.1.5.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсвийн тухай хууль, журмын дагуу зарцуулах, зарцуулалтанд хяналт тавих олон нийтийн хяналтын зөвлөлийг сум багт байгуулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
22.	1.1.6. Сумын гадаад болон дотоод харилцааг шинэ шатанд гаргаж харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж хөрөнгө оруулах чиглэлээр хамтран ажиллана.	1.1.6.1. Нийслэлийн дүүрэг, аймгийн төвийн сумдуудын ЗДТГ, баг хороодын ажлын туршлага судлах, шинэлэг, үр дүнтэй ажлаас суралцах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
23.	1.1.7. Аймаг сумын ажлын уялдаа холбоог сайжруулан үйл ажиллагааны чиглэл хариуцлагын тогтолцоог тодорхой болгоно.	1.1.7.1. Ажлын ачаалал, гүйцэтгэх чиг үүрэг, иргэдэд үзүүлэх үйлчилгээний эрэлт хэрэгцээг харгалзан, Засаг даргын Тамгын газрын орон тоо, бүтцийг шинэчлэн тогтоох	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
24.		1.1.7.2. Байгууллагын дотоод журам, үр дүнгийн гэрээнд төрийн албан хаагчийн ёс зүй, авлигаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой тусган, хяналт тавих, зөрчил бүрт арга хэмжээ тооцох	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
25.		1.1.7.3. Багуудын ажлын байранд хийгдэх засвар, эд хогшил, техник хэрэгслэлээр хангах зардлыг төсөвт тусган шийдвэрлэх	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Орон нутгийн төсвөөр
26.		1.1.7.4. “Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Жилдээ	ЗДТГ-ын дарга ДАХА	ЗДТГ-ын төсвөөр
ХОЁР. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ИРГЭДТЭЙ ОЮУНЛАГ ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ					
2.Боловсролын байгууллагын үйл ажиллагааг шинэчлэл хийх чиглэлээр:					
27.	2.1.1. Цэцэрлэгийн насны хүүхдийн хүмүүжих, сурч боловсрох таатай орчин бүрдүүлж материаллаг баазаар хангана.	2.1.1.1. Цэцэрлэгүүдийг сургалтын хэрэгсэл, багаж төхөөрөмж, тоглоомоор хангах, материаллаг нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Засаг дарга БСАХА	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Төслийн байгууллага

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

28.	2.1.2. Ерөнхий боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлж сургуулийн өмнөх боловсрол олгох, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2.1.2.1. Эрдэнэ багт баригдах сургуулийг эхлүүлэх, Их залуу багт 640 хүүхдийн багтаамжтай сургуулийг ашиглалтанд оруулах	Жилдээ	ЗДО БСАХА	Улсын төсөв
29.		2.1.1.2. 6 настай хүүхдүүдийг сургуульд хамруулах сургалтыг сайжруулах, сурах нөхцлийг бүрдүүлэх	Жилдээ	Засаг дарга БСАХА	
30.		2.1.1.3. Сурлага, урлаг, спортоор онцгой амжилт гаргасан сурагчдыг шагнаж урамшуулах	Жилдээ	Засаг дарга БСАХА	Засаг даргын нөөц сан
31.		2.1.1.4. Малчин багийн хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэх, зуны гэр цэцэрлэг ажиллуулах	Зуны сард	ЗДО БСАХА	Орон нутгийн төсвөөс
32.	2.1.2. Насан туршийн боловсролын хамрах хүрээг нэмэгдүүлж сургууль завсардалтыг бууруулж мэргэжлийн ур чадвар олгох сургалтанд хүүхэд залуучуудыг хамруулна.	2.1.2.1. Сургууль завсардсан сурагчдад бичиг үсгийн нөхөн болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтанд хамруулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
33.		2.1.2.2. Орон нутгийн сургалтын байгууллагуудыг түшиглэн мэргэжил олгох сургалт явуулах материаллаг нөхцлийг сайжруулж, залуучуудыг сургалтанд хамруулах	Жилдээ	ЗДО БСАХА	Нийгмийн халамжийн сангаас
34.	2.1.3. Их дээд болон мэргэжлийн сургуульд суралцагчдыг сурч боловсрох нөхцөлөөр ханган төрөөс үзүүлэх дэмжлэг, сургалтанд хамруулна.	2.1.3.1. Оюутан, сурагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулах	Жилдээ	БСАХА	Хөрөнгө шаардахгүй
35.		2.1.3.2. Мэргэжлийн сургуульд суралцагчдад ажлын байрны мэдээлэл өгөх, зуучлах, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулах	Жилдээ	ХНХҮХА БСАХА	Нийгмийн халамжийн сангаас
36.	2.1.4. Хүүхдийн эрхийг хамгаалах сурч хүмүүжих төлөвших тогтолцоог бий болгон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2.1.4.1. Эрдэнэ багийн соёлын төвийг тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах	Жилдээ	ХНХҮХА БСАХА	Орон нутгийн төсвөөс
37.		2.1.4.2. Ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүдийн хүмүүжлийн ажлыг сайжруулж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах	Жилдээ	БСАХА	Хөрөнгө шаардахгүй
38.		2.1.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсрох нөхцлөөр хангах, дэмжлэг үзүүлэх	Жилдээ	ХХҮХА БСАХА	Нийгмийн халамжийн сангаас
39.		2.1.4.4. Хүнд нөхцөлд амьдарч байгаа, насанд хүрээгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг судлаж, эрхийг хамгаалах	Жилдээ	ХНХҮХА БСАХА	Нийгмийн халамжийн сангаас
40.		2.1.4.5. Хүүхдийн халамж асрамжийн чиглэлээр	Жилдээ	ХНХҮХА	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

		үйл ажиллагаа явуулж буй гадаад дотоодын байгууллага аж ахуйн нэгжийг бүртгэх, хяналт тавих			
ГУРАВ.ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ИРГЭДТЭЙ ОРЧИН ЦЭВЭР ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ					
3.1.Эрүүл мэндийн байгууллагыг шинэчлэх чиглэлээр:					
41.	3.1.1. Эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байранд эрүүл мэндийг дэмжсэн орчин бүрдүүлнэ.	3.1.1.1. Эрүүл хот, сум, баг, ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
42.		3.1.1.2. Гэр хорооллын сургууль, цэцэрлэгүүдийн орчинд чийрэгжүүлэлтийн талбайг байгуулах	Жилдээ	ЗДО БСАХА	ОНХСангаас
43.		3.1.1.3. Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, иргэдэд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
44.	3.1.2. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эмнэлгийн үйлчилгээний чанар, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан тогтмол хүргэх.	3.1.2.1. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
45.		3.1.2.2. Халдварт болон халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдийн дунд зохион байгуулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
46.		3.1.2.3. ААН, байгууллагын ажиллагсдын дунд эрүүл хооллолт зөв амьдралын дадал зуршил эзэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
47.	3.1.3. Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээтэй холбож, хүртээмжийг дээшлүүлнэ.	3.1.3.1. Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, ДОХ-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх, оношлогоо, шинжилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, хувийн хэвшлийн лабораторийг оролцуулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
48.		3.1.3.2. Аж ахуйн нэгж байгууллага, орон сууц, айл өрхөд ариутгалт халдваргүйжүүлэлт хийх ажлыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй
49.		3.1.3.3. Багуудын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажиллах нөхцлийг сайжруулж, эмчилгээ оношлогооны багаж төхөөрөмжөөр хангах	Жилдээ	ЗДО БСАХА	Орон нутгийн төсвөөр
50.		3.1.3.4. Иргэдийн дунд нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулж, эрүүлжүүлэх дасгал хөдөлгөөнд хамруулах	Жилдээ	ЗДО БСАХА	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

51.		3.2.2.1. Соёлын төв, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй болгон техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хогшлоор ханган материаллаг баазыг сайжруулах	Жилдээ	ЗДО Соёлын төв, номын сангийн эрхлэгч	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар
52.	3.2.2. Хотын номын төв, соёлын төвийг материаллаг баазын хувьд бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	3.2.2.2. Урлагийн авъяастан шалгаруулах уралдаан тэмцээнийг иргэдийн дунд зохион явуулах, сурталчлах	Жилдээ	ЗДО БСАХА	Соёлын төвийн зардлаар
53.		3.2.2.3. Малчин багийн иргэдэд соёл, урлаг, явуулын номын сан ахуйн үйлчилгээг жилд 2-оос доошгүй удаа хүргэх	Жилдээ	ЗДО Малчин багийн Засаг дарга БСАХА	Соёлын төвийн зардлаар
54.		3.2.2.4. Соёл урлагийн бүтээл, түүхийн дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулах, сурталчлах	Жилдээ	ЗДО БСАХА	Сумын ЗД-ын нөөц сан
55.	3.2.3. Нийтийн биеийн тамир спортыг дэмжих, багуудад чийрэгжүүлэлтийн болон биеийн тамир спортын талбайг олноор байгуулна.	3.2.3.1. Орон сууцны дунд чийрэгжүүлэлтийн багаж хэрэгслийг суурилуулах, иж бүрэн тоглоомын талбай байгуулах	Жилдээ	ЗДО БСАХА	Орон нутгийн хөгжлийн сан
ДӨРӨВ. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ-ЧИНЭЭЛЭГ ИРГЭДТЭЙ ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ					
4.1 Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийн чиглэлээр:					
56.	41.1. Орон нутгийн засаг захиргаанаас олгодог, тусгай зөвшөөрөл, ажил үйлчилгээ явуулах эрх авахад тавигдах шаардлага, шалгуурыг хялбаршуулан, ажлын байр бий болгох аж ахуйн нэгж иргэнд шуурхай үйлчилдэг тогтолцоог бий болгоно.	4.1.1.1. Шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, ААН-ийг дэмжих, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, үзэсгэлэн худалдаа зохиох, чанар сав, баглаа боодлын стандартад хяналт тавих	Жилдээ	ЗДО ХҮҮХА БГТЖДҮҮХАХА	Хөрөнгө шаардахгүй
57.		4.1.1.2. Салбарын ажиллагсадын мэргэжлийн болон ур чадварыг дээшлүүлэх уралдаан тэмцээн, сургалт зохион байгуулах	Жилдээ	ЗДО ХҮҮХА	Хөрөнгө шаардахгүй
58.		4.1.1.3. Аж үйлдвэрийн паркийг түшиглэн Говил багт жижиг дунд үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх	Жилдээ	ЗДО ХҮҮХА БГТЖДҮҮХАХА	
59.		4.1.1.4. Орон нутгийн засаг захиргаанаас олгодог аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хяналтыг сайжруулж мэдээллийг ил тод болгох	Жилдээ	ЗДО ХҮҮХА БГТЖДҮҮХАХА	
60.	4.1.2. Сумын нутаг дэвсгэр, гудамж талбайд хуулиар хориглоогүй ажил үйлчилгээг ямар нэгэн зөвшөөрөл	4.1.2.1. Худалдаа үйлчилгээ эрхлэх боломжтой гудамж талбайн зураглал судалгааг гаргаж ажил үйлчилгээний нэр төрлийг тогтоох	Жилдээ	ЗДО ХҮҮХА	Хөрөнгө шаардахгүй
61.	хязгаарлалтгүйгээр эрүүл ахуй ариун	4.1.2.2. Эрүүл ахуй орчны тохижилт ариун	Жилдээ	ЗДО	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

	цэврийн нөхцөл хангасан тохиолдолд эрхлэх боломжийг иргэн бүрт олгоно.	цэврийг хангах талаар иргэн ААН, байгууллагатай гэрээ байгуулан ажил үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд чирэгдэлгүй болгох		ХҮҮХА	
62.	4.1.3. Жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих чиглэлээр малын гаралтай түүхий эд арьс шир, яс, ноос ноолууран бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, хүнсний ногоо	4.1.3.1. Үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах мал аж ахуй газар тариалангийн гаралтай түүхий эдийн нөөц бүрдүүлэх тооцоо судалгаа гаргах, төвлөрүүлэх бодлого баримтлах	Жилдээ	ЗДО МЭҮТ	Хөрөнгө шаардахгүй
63.	боловсруулах зэрэг үйлдвэрлэлийг дэмжин ажлын байрыг олноор бий болгоно.	4.1.3.2. Малын гаралтай арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэн техник технологийн дэмжлэг үзүүлэх	Жилдээ	ЗДО МЭҮТ	ААН-ийн хөрөнгө оруулалтаар
64.		4.1.3.3. Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Жилдээ	ЗДО МЭҮТ	Орон нутгийн төсвөөс
65.		4.1.3.4. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны тариалалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтлах	Жилдээ	ЗДО МЭҮТ	ААН-ийн хөрөнгө оруулалтаар
66.	4.1.5. Сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй, ажил олоход хүндрэлтэй байгаа болон 40-өөс дээш насны иргэдийг хөдөлмөрийн болон цахим биржээр ажилд	4.1.5.1. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгааг баг бүрээр гаргаж, нийтийг хамарсан, түр болон байнгын ажлын байраар хангах	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Хөрөнгө шаардахгүй
67.	зуучлах үйл ажиллагааг эрчимжүүлж, хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтын төвүүд, үйлдвэр, аж ахуйн нэгжид түшиглэсэн мэргэжлийн сургалт	4.1.5.2. Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байр бий болгох санаачлагыг дэмжин, хөнгөлттэй зээл, хөнгөлөлт үзүүлэх	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Сум хөгжүүлэх сангийн зээл
68.	үйлдвэрлэлийн төвүүдийн хөтөлбөрт сургалтанд хамруулан мэргэжил эзэмшүүлнэ.	4.1.5.3. Ажилд зуулчлах үйлчилгээг хөдөлмөрийн болон цахим биржээр холбогдох байгууллагатай хамтран үзүүлэх	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас
4.2 Нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр					
69.		4.2.1.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд иргэдийг хамруулах, үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
70.		4.2.1.2. Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг судлан нийгмийн халамж, тусламж дэмжлэг үзүүлэх	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
71.		4.2.1.3. Нийгмийн хөгжлийн үйлчилгээг тухайн	Жилдээ	ЗДТГ-ын дарга	Халамжийн сангаас

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

		зорилтот бүлэгт чиглүүлэн чирэгдэлгүй шуурхай үзүүлэх		ХНХҮХА	
72.		4.2.1.4. Гамшигт осолд өртсөн өрх, нэн ядуу иргэн, ганц бие, хорихоос суллагдсан иргэн, өрх толгойлсон эмэгтэй, ахмад настнуудад гэр олгоход туслах	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
73.	4.2.1. Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.	4.2.1.5. Ихэр хүүхэд төрүүлсэн иргэн,байнгын асаргаа шаардлагатай хүүхэд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх/ эцгийг мөнгөн тэтгэмжид хамруулах	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
74.		4.2.1.6 Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн халамжийн тэтгэвэрт хамруулах	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	НХСангаас
75.		4.2.1.6. Зорилтот бүлгийн иргэдийг асаргааны тэтгэмжид бүрэн хамруулах, орон гэргүй иргэдэд дэмжлэг үзүүлэх	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	НХСангаас Орон нутгийн төсвөөс
76.	4.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж, халамжийг нэмэгдүүлнэ.	4.2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ААН байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах тухай хууль тогтоомжийн заалтыг хэрэгжилтэнд хяналт тавих	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
77.		4.2.3.1. Сум, багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, өрх, иргэдийг судлах, нийгмийн халамж, тэтгэмж олгох талаар гаргасан шийдвэрийн хэрэгжүүлэлтэнд хяналт тавих	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
78.	4.2.3. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, ахмад үеийн мэдлэг, чадварт тулгуурлан өрхийн орлого нэмэгдүүлэхэд туслана.	4.2.3.2. Ахмадуудын хоршин ажиллах, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулах санал санаачилгыг дэмжиж хамтарч ажиллах, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтөнд хамруулах	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
79.		4.2.3.3. Ахмад настны хүндэтгэл үзүүлэх	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	НХСан, Орон нутгийн төсвөөс
80.		4.2.3.4. Ахмадын байрыг барих ажлыг эхлүүлэх	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Улсын төсвөөс

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

81.		4.2.3.5. Тусламж дэмжлэг, халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд үзүүлэх	Жилдээ	Засаг дарга ХНХҮХА	Халамжийн сангаас
82.		4.2.3.6. Эрдэнэтийн бүтээн байгуулалтанд оролцсон ажлын үр дүн амжилтыг харгалзан салбарын болон төрийн дээд шагналд тодорхойлж урамшуулах	Жилдээ	Засаг дарга	Хөрөнгө шаардахгүй
4.3. Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарын чиглэлээр:					
83.	4.3.1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлнэ.	4.3.1.1. ”Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Хөтөлбөрийн санхүүжилтээр
84.		4.3.1.2. Шилмэл үүлдэр омог хэвшлийн өсвөр хээлтүүлэгч малыг өсгөн бойжуулах, хээлтүүлэгч малын чанар үүлдэр угсааг сайжруулах зорилгоор өсвөр хээлтүүлэгч худалдан авах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
85.		4.3.1.3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг ариун цэврийн шинжилгээнд хамруулж, зах, худалдаа үйлчилгээний төвүүдийн стандартыг мөрдүүлж тавих хяналтыг сайжруулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	
86.		4.3.1.4. ”Хүнсний аюулгүй байдал” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Хөтөлбөрийн санхүүжилтээр
87.		4.3.1.5. Баян-Өндөр суманд малын бүртгэл, мэдээллийн сан сүлжээ бий болгох	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Орон нутгийн төсвөөс
88.		4.3.1.6. Хөдөө аж ахуйн дэвшилтэт технологийн сургалт, мэдээлэл сурталчилгааг тодорхой цаг үеүүдэд нэвтрүүлэх. Зайны сургалтыг зохион байгуулах.	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Орон нутгийн төсвөөс
89.		4.3.1.7. Сүү, махны үүлдрийн үхрийн тоо толгойг нэмэгдүүлэх, малчдыг шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчийг үржилд ашиглах санаачлагыг дэмжих, зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

90.		4.3.1.8. “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих”, “Зоорь хүлэмжийн аж ахуйг дэмжих журам”-ын хэрэгжилтийг хангах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Орон нутгийн төсвөөс
91.		4.3.2.1. Фермерийн аж ахуйг хөгжүүлэх, малчид тариаланчдад шинэ технологи, бага дунд оврын техник тоног төхөөрөмж нэвтрүүлэх	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ЖДҮ-ийг дэмжих сангаас
92.	4.3.2. Амьжиргааны орлогын төрөл бүрийн эх үүсвэртэй болох иргэдийн санаачилгыг дэмжин эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуй, газар тариалан эрхлэх, төмс, хүнсний ногоо тариалагчдыг жижиг оврын техник хэрэгслээр хангах, хүлэмж, зоорь, агуулах барих иргэд аж ахуйн нэгжийг дэмжинэ.	4.3.2.2. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн түүхий эд арьс шир худалдан борлуулах дэлгүүр, зах байгуулахад дэмжлэг үзүүлж хотын төвөөс зайдуу төвлөрсөн зах байгуулах бодлого баримтлах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	
93.		4.3.2.3. Төмс, хүнсний ногоо хадгалах зоорины тоог нэмэгдүүлж, арчлах, бордох, хураах, ургамал хамгаалах технологийн сургалт зохион байгуулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Тариалан эрхлэгчдийг дэмжих сангаас
94.		4.3.2.4. Шинээр байгуулж байгаа ХАА-н сургалт, туршилтын төвийн үйл ажиллагааг эхлүүлэх, төрөл бүрийн шинэ сортын үр үрсэлгээг тарих, нутагшуулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
95.		4.3.2.5. Сумын аюулгүйн фондонд хадлан тэжээл бэлтгэх шаардлагатай бага оврын трактор хаман боогч/ пресс/ худалдан авах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
96.		4.3.2.6. Зуны болон өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжих	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Төсөл хөтөлбөрөөр
97.	4.3.3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, төмс, хүнсний ногооны төрөлжсөн бөөний худалдааны зах, цэг салбар нээн ажиллуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.	4.3.3.1. Гахай, шувууны аж ахуйг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ЖДҮ-ийг дэмжих сангаас
98.		4.3.3.2. Иргэдийг дотоодын хүнсний ногоогоор хангах, худалдан борлуулах бөөний цэгийн тоог нэмэгдүүлэх	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ААН-ийн хөрөнгөөр
99.	4.3.4. Сумын малчдын хадлан тэжээл бэлтгэх болон өвөлжөө, хаваржаа нутаг бэлчээрийн асуудлыг Мянганы сорилын сангийн хот орчмын бэлчээрийн менежментийн төсөл болон Булган, Сэлэнгэ аймаг, Бугат, Хангал, Орхон, Сэлэнгэ, Баруунбүрэн сумын удирдлагатай хэлэлцэн гэрээ байгуулж	4.3.4.1. Мянганы сорилтын сангийн хот орчмын бэлчээрийн төсөлд хамрагдсан малчдын бүлгийг чадавхжуулах,	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Төслийн хөрөнгөөр
100.		4.3.4.2. Малчдад төрийн үйлчилгээг хүргэх, мал сүргийг өвөлжүүлж, хаваржуулах, хөрш зэргэлдээ аймаг, сумдтай бэлчээр хадлангийн талбайн зохицуулалт хийх	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Хөрөнгө шаардахгүй
101.		4.3.4.3. Бэлчээрийн усан хангамж, хадлан тэжээл	Жилдээ	ЗДО	ОНХС-ийн хөрөнгө

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2013

	шийдвэрлэнэ. Малчдын нөхөрлөл хоршоог дэмжинэ.	бэлтгэлт, бэлчээрийн даацыг зохицуулах нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн аймгийн нөөц боломжийг ашиглан шийдвэрлэх		МЭҮ-ийн тасаг	
102.	4.3.5. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг шинэ шатанд гаргана.	4.3.5.1. Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг ариутгал, вакцинжуулалтанд хамруулах, үр дүнг сайжруулж, өвчин гарах, тархах нөхцлийг хязгаарлах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	Мал эмнэлгийн зардлаар
103.		4.3.5.2. Сумын нийт үхэр сүргийг лейкоз өвчнөөс эрүүлжүүлэх тандах шинжилгээ хийх	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
104.		4.3.5.3. Сумын хэмжээнд эзэнтэй нохойг пайзжуулж, гэрчилгээжүүлж, мал эмнэлгийн арга хэмжээнд хамруулж эрүүлжүүлэх, золбин нохойны нөхөн үржихүйг хязгаарлах ажлыг мал эмнэлэгийн дэвшилтэт арга барилыг ашиглан бууруулах	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
105.		4.3.5.4 ХАА-н сургалт, туршилтын төвд шинээр баригдсан инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэх	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг	ОНХС
106.	4.3.6. Хүн амын хүнсний хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй бүтээгдэхүүнээр хангаж, түүнд тавих хяналтыг сайжруулна.	4.3.6.1. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавих	Жилдээ	ЗДО МЭҮ-ийн тасаг ХҮҮХА	Хөрөнгө шаардахгүй
107.		4.3.6.2. Хотын усан хангамж хүрэлцээ чанар ариун цэвэрт хяналт тавих, иргэдийн хувиараа хашаандаа гаргасан худгийн усны чанарыг мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх	Жилдээ	ЗДО БОХ-улсын байцаагч	Хөрөнгө шаардахгүй
108.		4.3.6.3. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулалт үйлчилгээний цагийн хуваарийн мөрдөлтөнд хяналт тавих	Жилдээ	ЗДО ХҮҮХА	Хөрөнгө шаардахгүй
109.		4.3.6.4. Тамхи ширхэглэн борлуулах, стандартын бус архи худалдах, гар дээрээс борлуулах зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилдээ	ЗДО ХҮҮХА	Хөрөнгө шаардахгүй
110.		4.3.6.5. “Нэг баг-нэг бүтээгдэхүүн” уралдааныг зарлаж шалгарсан бүтээгдэхүүнийг сумын “Бренд” бүтээгдэхүүнээр тодруулах	Жилдээ	ЗДО ХҮҮХА	Орон нутгийн төсвөөс

4.4. Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих чиглэлээр:					
